

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Мөнгөн хараа дуу, бүжгийн чуулгын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/144-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага	19
5.3 Зөвлөмж	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТЕЗ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.25 № САА-2023/144-НАСА-ТУС

танай _____-ны № _____-г

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ
СУМЫН МӨНГӨН ХАРАА ДУУ
БҮЖГИЙН ЧУУЛГЫН ДАРГА
Б.АСАЛБЕК ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мандал сумын Мөнгөн хараа чуулгын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 89.0 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 7.0 хувиар, НДШ-ийн зардлыг 5.0 хувиар, тогтмол зардлыг 3.0 хувиар, хангамж, бараа материалын зардлыг 52.0 хувиар, бараа, үйлчилгээний бусад зардлыг 53.0 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 11.0 хувиар хэмнэгдсэн байна.

Үндсэн үйл ажиллагаагаар 26,510.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Мандал сумын Мөнгөн хараа чуулгын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 65.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн, 10.9 хувийг эд хогшил, урсгал засварын, 10.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	169,029,695.00	221,513,478.21
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	38,750,903.21
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	0.00	38,750,903.21
31210	Төгрөг	0.00	38,750,903.21
31211	Төрийн сангийн харилцах	0.00	38,750,903.21
35	БАРАА МАТЕРИАЛ	169,029,695.00	182,762,575.00
35400	Хангамжийн материал	169,029,695.00	182,762,575.00
35410	Бичиг хэргийн материал	214,420.00	146,200.00
35420	Аж ахуйн материал	19,466,107.00	27,314,107.00
35450	Барилгын засварын материал	4,620,100.00	4,607,600.00
35470	Бусад хангамжийн материал	144,729,068.00	150,694,668.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,375,735,352.79	1,279,823,628.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,375,735,352.79	1,279,823,628.29
39200	Биет хөрөнгө	1,272,685,352.71	1,177,023,628.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,143,232,200.00	1,143,232,200.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-86,125,388.23	-111,645,601.51
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,440,000.00	89,440,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34,879,999.96	-62,159,999.92
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	212,214,024.33	215,138,324.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	-118,617,627.20	-155,330,498.06
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,767,426.00	21,767,426.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,919,136.96	-10,313,278.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	71,864,613.56	71,864,613.56
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,290,758.83	-24,969,557.35
39300	Биет бус хөрөнгө	103,050,000.08	102,800,000.12
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-749,999.92	-999,999.88
39303	Бусад биет бус хөрөнгө	102,300,000.00	102,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,544,765,047.79	1,501,337,106.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,544,765,047.79	1,501,337,106.50
51	Засгийн газрын хувь оролцоо	1,544,765,047.79	1,501,337,106.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,143,543,879.70	1,143,543,879.70
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,143,543,879.70	1,143,543,879.70
51200	Хуримтлагдсан үр дүн	-254,568,422.84	-297,996,364.13
51210	Өмнөх үеийн үр дүн	-325,380,165.70	-254,568,422.84
51220	Тайлант үеийн үр дүн	70,811,742.86	-43,427,941.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	655,789,590.93	655,789,590.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,544,765,047.79	1,501,337,106.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	898,578,298.20	857,632,672.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,681,774.73	31,169,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	175,681,774.73	31,169,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,771,700.00	26,210,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,771,700.00	26,210,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	166,260,074.73	2,104,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,650,000.00	2,854,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	722,896,523.47	826,463,472.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	47,330,200.00	643,237,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	47,329,500.00	643,237,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,820,350.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,820,350.00	300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	670,745,973.47	182,925,572.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	670,745,973.47	182,925,572.82
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	780,436,355.34	901,060,614.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	780,436,355.34	901,060,614.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731,932,005.34	900,292,614.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	470,845,730.91	475,304,671.43
210101	Үндсэн цалин	375,199,009.16	330,585,888.35
210102	Нэмэгдэл	81,153,591.00	84,875,077.70
210104	Урамшуулал	0.00	30,962,498.38
210105	Гэрээт ажлын хөлс	14,493,130.75	28,881,207.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,295,357.58	60,243,359.96
210201	Тэтгэврийн даатгал	43,289,461.32	41,699,369.04
210202	Тэтгэмжийн даатгал	4,750,458.44	4,427,856.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,787,765.33	4,114,312.44
210204	Ажилгүйдлийн даатгал	816,459.75	797,186.37
210205	Эрүүл мэндийн даатгал	8,651,212.74	9,204,635.73
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,039,104.98	88,779,145.22
210301	Гэрэл, цахилгаан	3,230,298.79	4,462,126.72
210302	Түлш, халаалт	71,398,486.19	81,941,614.50
210303	Цэвэр, бохир ус	410,320.00	2,375,404.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,545,380.00	3,380,080.00
210401	Бичиг хэрэг	550,230.00	740,720.00
210402	Тээвэр, шатахуун	1,224,650.00	1,369,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	784,600.00	680,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	150,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,985,900.00	0.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.00	440,000.00
2105	Нормативт зардал	59,500.00	537,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	59,500.00	537,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,934,650.00	86,356,883.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	399,650.00	0.00
210604	Урсгал засвар	2,535,000.00	86,356,883.00

2107	Томилолт, зочны зардал	28,000.00	526,800.00
210702	Дотоод албан томилолт	28,000.00	526,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,223,000.00	49,870,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,123,000.00	49,870,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,961,281.87	135,293,424.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,050.00	36,457,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,611,231.87	98,836,024.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,495,300.00	768,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,495,300.00	768,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,778,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	716,700.00	768,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-604,745,530.61	-43,427,941.29
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-604,745,530.61	-43,427,941.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	677,338,023.47	852,674,272.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	26,510,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	26,510,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	26,510,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	26,510,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	677,338,023.47	826,163,472.82
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	643,237,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	643,237,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,592,050.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,820,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	350.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,771,350.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	670,745,973.47	182,925,572.82
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	670,745,973.47	182,925,572.82
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	677,338,023.47	813,103,469.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	677,338,023.47	813,103,469.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,833,673.47	812,335,469.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	470,845,730.91	475,304,671.43
210101	Үндсэн цалин	375,199,009.16	337,899,704.35
210102	Нэмэгдэл	81,153,591.00	79,818,017.70
210104	Урамшуулал	0	30,962,498.38
210105	Гэрээт ажлын хөлс	14,493,130.75	26,624,451.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,295,357.58	60,243,359.96
210201	Тэтгэврийн даатгал	43,289,461.32	41,699,365.66
210202	Тэтгэмжийн даатгал	4,750,458.44	4,427,856.38

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,787,765.33	4,114,315.44
210204	Ажилгүйдлийн даатгал	816,459.75	876,291.74
210205	Эрүүл мэндийн даатгал	8,651,212.74	9,125,530.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,160,654.98	88,779,145.22
210301	Гэрэл, цахилгаан	3,230,298.79	9,583,312.72
210302	Түлш, халаалт	71,398,486.19	76,820,428.50
210303	Цэвэр, бохир ус	531,870.00	2,375,404.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,497,930.00	2,739,860.00
210401	Бичиг хэрэг	610,230.00	540,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,103,100.00	1,369,060.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	784,600.00	680,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,033,300.00	150,000.00
2105	Нормативт зардал	6,033,300.00	1,275,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	399,650.00	1,275,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	89,061,233.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	399,650.00	2,491,200.00
210604	Урсгал засвар	0	86,570,033.00
2107	Томилолт, зочны зардал	28,000.00	526,800.00
210702	Дотоод албан томилолт	28,000.00	526,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,223,000.00	51,571,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,123,000.00	51,571,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,050.00	42,833,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	350,050.00	42,833,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,504,350.00	768,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,495,300.00	768,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,778,600.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	716,700.00	768,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,050.00	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,050.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	39,570,803.21
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	819,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	819,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	819,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	819,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-819,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	38,750,903.21
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	38,750,903.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-325,380,165.70	1,473,953,304.93
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-325,380,165.70	1,473,953,304.93
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	70,811,742.86	70,811,742.86
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-254,568,422.84	1,544,765,047.79
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-254,568,422.84	1,544,765,047.79
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-43,427,941.29	-43,427,941.29
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,143,543,879.70	655,789,590.93	-297,996,364.13	1,501,337,106.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	914,267,900.00	813,923,369.61	-100,344,530.39	89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	914,267,900.00	813,923,369.61	-100,344,530.39	89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	913,499,900.00	812,335,469.61	-101,164,430.39	89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,836,200.00	475,304,671.43	-33,531,528.57	93
210101	Үндсэн цалин	331,928,300.00	337,899,704.35	5,971,404.35	102
210102	Нэмэгдэл	124,894,000.00	79,818,017.70	-45,075,982.30	64
210104	Урамшуулал	10,843,900.00	30,962,498.38	20,118,598.38	286
210105	Гэрээт ажлын хөлс	41,170,000.00	26,624,451.00	-14,545,549.00	65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,604,600.00	60,243,359.96	-3,361,240.04	95
210201	Тэтгэврийн даатгал	43,624,400.00	41,699,365.66	-1,925,034.34	96
210202	Тэтгэмжийн даатгал	4,971,900.00	4,427,856.38	-544,043.62	89
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,019,200.00	4,114,315.44	95,115.44	102
210204	Ажилгүйдлийн даатгал	999,000.00	876,291.74	-122,708.26	88
210205	Эрүүл мэндийн даатгал	9,990,100.00	9,125,530.74	-864,569.26	91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,339,500.00	88,779,145.22	-2,560,354.78	97
210301	Гэрэл, цахилгаан	6,496,900.00	4,462,126.72	-2,034,773.28	69
210302	Түлш, халаалт	81,894,700.00	81,941,614.50	46,914.50	100
210303	Цэвэр, бохир ус	2,947,900.00	2,375,404.00	-572,496.00	81
2104	Хангамж, бараа материалын зардал	5,737,200.00	2,739,860.00	-2,997,340.00	48

210401	Бичиг хэрэг	610,300.00	540,500.00	-69,800.00	89
210402	Тээвэр, шатахуун	2,103,600.00	1,369,060.00	-734,540.00	65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,023,300.00	680,300.00	-343,000.00	66
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	150,000.00	-650,000.00	19
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	0.00	-1,200,000.00	0
2105	Нормативт зардал	3,516,400.00	1,275,300.00	-2,241,100.00	36
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,516,400.00	1,275,300.00	-2,241,100.00	36
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,613,700.00	89,061,233.00	-4,552,467.00	95
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	2,491,200.00	-8,800.00	100
210604	Урсгал засвар	91,113,700.00	86,570,033.00	-4,543,667.00	95
2107	Томилолт, зочны зардал	649,100.00	526,800.00	-122,300.00	81
210702	Дотоод албан томилолт	649,100.00	526,800.00	-122,300.00	81
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,850,000.00	51,571,300.00	-1,278,700.00	98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,850,000.00	51,571,300.00	-1,278,700.00	98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,353,200.00	43,653,700.00	-49,699,500.00	47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	93,353,200.00	43,653,700.00	-49,699,500.00	47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768,000.00	768,000.00	0.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	768,000.00	768,000.00	0.00	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	768,000.00	768,000.00	0.00	100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	914,267,900.00	852,674,272.82	-61,593,627.18	93
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	643,237,900.00	643,237,900.00	0.00	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	643,237,900.00	643,237,900.00	0.00	100
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,496,900.00	182,925,572.82	-2571327.18	99
320001	Орон нутгийн төсвөөс	185,496,900.00	182,925,572.82	-2571327.18	99
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	85,533,100.00	26,510,800.00	-59,022,300.00	31
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,533,100.00	26,510,800.00	-59,022,300.00	31
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	38,750,903.21	38,750,903.21	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	85	85	0	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	42	42	0	100
620001	Удирдах ажилтан	1	1	0	100

620002	Гүйцэтгэх ажилтан	36	36	0	100
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	42	0	100
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСҮ)	42	42	0	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга /Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга/ нь “Нийгмийн баялгийг чанартай бүтээн туурвиж, ард иргэдийн оюунд соёлын хөрөнгө оруулалт хийж хөгжүүлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Соёл урлагийн олон талт үзвэр үйлчилгээгээр ард иргэдийг соён гэгээрүүлэх,
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх,
- Чанартай, хүртээмжтэй уран бүтээл туурвих.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт тавьж ажилладаг бөгөөд тайлант онд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч Соёлын яамны ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын онцлогт тохироогүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43,427.9 мянган төгрөгөөр бууу 2.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	38,750.9	38,750.9
Бараа материал	169,029.7	182,762.6	13,732.9
Үндсэн хөрөнгө	1,375,735.3	1,279,823.6	-95,911.7
Нийт хөрөнгө	1,544,765.0	1,501,337.1	-43,427.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,544,765.0	1,501,337.1	-43,427.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,544,765.0	1,501,337.1	-43,427.9

Мөнгөн хөрөнгө данс 38,750.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь гүйцэтгэлээр санхүүждэг болсноос шалтгаалан төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 182,762.6 мянган төгрөг болж 13,732.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 38,298.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон хандиваар 2,854.0 мянган төгрөгийн бараа материал хүлээн авч, 27,419.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,642,318.3 мянган төгрөг болж 2,924.3 мянган төгрөгөөр өссөн нь 819.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан болон 2104.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар хүлээн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,501,337.1 мянган төгрөг болж 43,427.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 628,533.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 99,445.4 мянган төгрөг, нийт зарлагыг 727,979.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Эд хогшил, урсгал засварын зардлыг 77,590.2 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 353.2 мянган төгрөгөөр зэрэг **77,943.4** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 39,092.8 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 12,791.4 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 4,643.1 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 1,906.7 мянган төгрөгөөр,
- Томилот, зочны зардлыг 1,929.7 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 83.5 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 1,650.0 мянган төгрөгөөр зэрэг **62,097.2** мянган төгрөгөөр бууруулж, нийт **743,825.5** мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 170,442.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 20,927.7 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 2,616.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 40,180.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 93,000.0 мянган төгрөгөөр г.м/ төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 643,237.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 185,496.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 85,533.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 643,237.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 182,925.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 26,510.8 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 813,923.4 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны орлого 59,022.3 мянган төгрөгөөр дутуу төвлөрснөөс шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	602,469.9	564,382.1	38,087.8	93.7
2	Уран бүтээл хийлгэх	40,000.0	39,637.5	362.5	99.1
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	768.0	768.0	0.0	100.0
4	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	85,533.1	26,210.2	59,322.9	30.6
5	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	172,453.2	169,882.0	2,571.2	98.5
6	Нийтлэг үйлчилгээ	13,043.7	13,043.6	0.1	99.9
	Дүн	914,267.9	813,923.4	100,344.5	89.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын нэмэлт санхүүжилтийн 100130435406 тоот дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16,845.3 мянган төгрөг төвлөрснийг тус байгууллагын урсгал зардлын 100130435094 дансанд шилжүүлэн, зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн анхан шатны баримттай холбоотой, санхүүгийн тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 780,436.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **7,804.4** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга нь дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Байгууллагын тайзны цахилгаан их хэрэглэгддэг хуучин пар, гэрлүүдийг шинэчлэн орчин үеийн лед, паран гэрлүүдээр шинэчилсэн,
- Чуулгын байрны халаалтыг гэрээний дагуу төлж нэмэлт цахилгаан халаагуур залгахгүйгээр дулаан алдалтыг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан цонх, хаалгыг дулаалсан,
- Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэн ажилласан,

- Соёлын яам болон Сэлэнгэ аймгийн Соёл урлагийн газраас зохион байгуулж буй сургалтуудад цахимаар оролцож бусад зардлыг хэмнэн ажилласан гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Мөнгөн хараа дуу бүжгийн чуулга нь мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 8 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Дараа жилийн төсвийн төслийг 1 удаа,
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 2 удаа,
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 удаа,
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг 2 удаа
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг 1 удаа
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 1 удаа
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 1 удаа

Огт мэдээлээгүй:

- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайланг 1 удаа
- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайланг 1 удаа
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 2 удаа,
- Санхүүгийн тайланг 1 удаа,
- Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 1 удаа,
- Худалдан авах ажиллагааны тайланг 1 удаа,

- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 1 удаа,

Шийдвэрлэлт: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан тул сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг илүү олгосон 3,597.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, бэлэн мөнгөний орлогыг төрийн сангийн харилцах дансанд 4-13 хоногийн дараа тушаасан 1,171.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн боловч 44,765.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	3,597.1	1	3,597.1	100.0
Зөвлөмж	2	45,937.6	1	44,718.8	50.0
Нийт дүн	3	49,534.7	2	30,782.9	66.7

Өмнөх онд өгөгдсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагч болон Сангийн яамны өгсөн чиглэлээр хэрэгжсэн дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *“Чиглэл хүргүүлэх тухай”* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан *“Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан”* гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар, өөрөөр хэлбэл өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалснаар тайлагнагдаж байна.

Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт шилжүүлсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр эх үүсвэр хэлбэрээр төлөвлөж, зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.

2. Тус байгууллагын дарга Б.Асалбек, нягтлан бодогч Н.Тунгалаг нарт улирлын ажлын мөнгөн урамшууллыг тухай бүр олгож байсан боловч Мандал сумын Засаг даргын 2022 оны 08 сарын 18-ны өдрийн А/297 дугаар, 09 сарын 29-ний өдрийн Б/59 дүгээр захирамжуудаар санхүүгийн тайланг *“Зөрчилгүй”* дүгнүүлсэн гэх үндэслэлээр үндсэн цалингийн 100 хувиар тооцон урамшуулал олгохоор шийдвэрлэсний дагуу улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан **1,637.0** мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”*, 15.1.3: *“Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Цаашид улирлын ажлын мөнгөн урамшуулалтай давхардуулан, хууль, эрх зүйн үндэслэлд нийцээгүй урамшуулал олгохгүй байх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **15,088.3** мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 2,044.0 мянган төгрөгийн орлогыг бараа материалын тодруулгад худалдаж авснаар бүртгэсэн,
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөгөөг 13,044.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт **1,573.1** мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 354.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,218.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчил арилгах 2 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Үйл ажиллагааны орлогын тооцоог тухай бүр хянаж, баталгаажуулаагүйгээс касст бэлнээр авсан заалны түрээсийн **354.3** мянган төгрөгийн орлогыг дутагдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Дутагдуулсан орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **1,218.8** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь *“Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх *“Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”*, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Албан хаагчдад илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг олгохдоо холбогдох журамд заасан *“Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”*-аар тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.1 дэх *“Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан*

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Албан хаагчдад нэмэгдэл хөлс олгохдоо дээрх журмын дагуу тооцон, холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллах.

3. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна, 8.1.5.”санхүүгийн тайлангийн тодруулга.” гэсэн заалт болон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар, журмын дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх нь зүйтэй.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг бараа материалын тодруулгад худалдаж авснаар бүртгэсэн	1	2,044.0			1	2,044.0	1	2,044.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн төлөвлөгөөг дутуу тайлагнасан	1	13,044.3			1	13,044.3	1	13,044.3				
Дүн	2	15,088.3			2	15,088.3	2	15,088.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үйл ажиллагааны орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлэлгүйгээр дутагдуулсан	1	354.3	1	354.3								
Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг	1	1,218.8			1	1,218.8						

гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан												
Албан хаагчдад илүү цагаар ажилласан нэмэгдэл хөлсийг олгохдоо холбогдох журамд заасан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-аар тооцоо хийгээгүй	1						1					
Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байна.	1						1					
Дүн	4	1,573.1	1	354.3	1	1,218.8	2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Хугацаа хоцроож мэдээлсэн	9				9				
Огт мэдээлээгүй	8				8				
Дүн	17				17				
Нийт дүн	17				17				